

**МАХН-ЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
ТӨЛӨШИЛТИЙН АСУУДАЛД**

**С.Мөнхбат**

Докторант

(МУИС, Улс төр судлалын тэнхмийн багш)

**Хураангуй.** Аливаа нам ардчиллын тээж, түгээн дэлгэрүүлэх үүргийг нийгмийн өмнө хүлээж байдагтай уялдан ардчиллын бэхжилтийг намын төлөвшилттэй холбон авч үздэг билээ. Орчин үеийн улс төрийн намын шинэчлэл, хөгжлийн асуудалтай уялдан манай улс төрд голлох үүрэгтэй намуудын нэг болох МАХН-ын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтөд оршиж буй зарим нэг дутагдлыг тус намын үндсэн дүрэм бусад хууль, эрхийн баримт бичгүүдэд задлан шинжилгээ хийх замаар тодруулахыг эрмэлзэв.

**Түлхүүр үг.** Эрх мэдлийн хуваарилалт, их хурал, удирдах байгууллага, удирдах зөвлөл, орон нутгийн байгууллага, гишүүд дэмжигчид, дотоод ардчилал, бүтэц, зохион байгуулалт

Тусгаар тогтнолоо олж, шашин төрөө мандуулах нэг ижил зорилготой, Монголын дунд ангийн сэхээтнүүдийг эгнээндээ нэгтгэсэн Консулын (Бодоо, Чагдаржав, Чойбалсан, түшмэл Жамъян, лам Лосол)<sup>1</sup> болон, Хүрээний (Данзан, Догсом, Сүхбаатар, Дугаржав, Галсан, Тогтох, Даш)<sup>2</sup> хоёр бүлгээс эх авж улмаар 1921 оны III сарын 1-нд МАН-ыг байгуулсанаар МАХН-ын түүх эхэлсэн байдаг. Энэ цаг үеэс тооцож үзэхүл МАХН бол Монголын анхны ууган нам бөгөөд өдгөө 87 нас хүрч байна. Тус намын үүсэл, төлөвшлийн эхний жилүүдэд Монгол орныг “жинхэнэ ардын ёсыг баримтлан”, үндэсний өвөрмөц онцлог бүхий улс болгон хөгжүүлэх, түүний хүрээнд янз бүрийн үзэл баримтлал дэвшигдэж байсан юм. Тухайлбал, нийгэм алгасан хөгжихөд зайлшгүй бодолцох хүчин зүйл, дэлхийн соёл иргэншлийн буй болгосон үнэт зүйлсийг ашиглах тухай С.Данзангийн үзэл баримтлал, социализмд хүрэх монголжуу замын тухай Ж.Цэвээний онолын үндэслэл, улс орны нийгмийн хөгжлийн талаарх “баруунтан” гэгчдийн үзэл санаа, төсөөлөл зэрэг бүрэн дүүрэн боловсроогүй ч гэсэн олон үзэл санааны чиг баримжаалал түүнийг Монгол орны нөхцөлд бүтээлчээр хэрэглэх гэсэн өвөрмөц оролдлогууд байсан юм.

МАХН нь үүсэн бий болсон цагаасаа олон түмний намын шинжээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа, үзэл суртал, бүтэц зохион байгуулалт, нийгмийн бааз суурь нь нийгмийн дундаж олонхийн давхаргад суурилж байсан юм. Нийгмийн хөгжлийн явцад улс орныг хамарсан нэг хүн, нэг үзэл суртлыг тахин шүтэх тогтолцооны гажуудлаас үүдэн тус намын нийгмийг удирдах үйл ажиллагаа нийт ард олныг дангаар захирах нэг намын төржсөн тогтолцоо руу хөтөлсөн билээ.

1990 оны ардчилсан хувьсгалаар нийгмийн тогтолцоог сууриар нь өөрчилсөнөөр МАХН хуучин уламжлалт байр сууринаасаа татгалзаж, үзэл суртал, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд орчин үеийн улс төрийн намын хөгжлийн жишигт хүрэхүйц нам болон төлөвших алхамуудыг хийсээр байгаа билээ. Үүний нэг тод илрэл нь МАХН-ын XX их хурлаас намын мөрийн хөтөлбөр, дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тал бүрээс нь тунгаан хэлэлцэж намын шинэчлэлт зарчмын ач холбогдол бүхий шийдвэр гаргасан нь

<sup>1</sup> \ÀŌí-úí ò¿¿ òýí òíà=íí.ÓÁ.,2001 íí.òóóààñ.8

<sup>2</sup> \ÀŌí-úí ò¿¿ òýí òíà=íí.ÓÁ.,2001 íí.òóóààñ.8

намын дүрэмд нам дотор жигүүр байхыг хүлээн зөвшөөрсөн явдал байсан. “МАХН-ын XXII их хурал намын онол суртахууны үзэл баримтлалыг шинээр томъёолж, намын XXIII их хурал намын шинэ зууны бодлогыг тодорхойлж, XXIV их хурал намын ажлын шинэчлэлийн талаар зарчмын дүгнэлтүүдийг гаргаж тодорхойлсон”<sup>3</sup> байдаг.

Гэвч нийгмийн бодит байдал, хөгжлийн хурдцыг түрүүлэн гүйцэж удирдан чиглүүлэхийн тулд эрх барьж буй МАХН-д шинэчлэлт, хөгжлийн алс хэтийн стратеги ус агаар мэт чухал ач холбогдолтой хэвээр байна. Энд МАХН-ын шинэчлэлийн талаар олон талын асуудлыг хөндөн ярьж болох боловч шинэчлэлийн гараа, үндсэн суурь болсон бүтэц зохион байгуулалтын асуудлыг тусгайлан авч үзэхийг эрмэлзэв.

2005 оны 6 дугаар сарын 16-аас 19-нд хуралдсан МАХН-ын XXIV их хурлаас 2005 онд шинэчлэгдэж батлагдсан “Улс төрийн намын тухай” Монгол улсын хуульд нийцүүлэн намын дүрмийг шинэчлэн найруулж баталсан явдал нь намын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, ардчилахад чиглэсэн томоохон алхам болсон юм. Гэвч МАХН-ын шинэ дүрэмд хуучин, уламжлалт, хатуу зохион байгуулалтын бүтцийг тогтооход чиглэсэн зүйл, заалтууд нэлээдгүй байгаа нь намын ардчилагдах, шинэчлэгдэх үйл явцад тээг болох нөхцлийг бүрдүүлж байна.

Дэлхийн ардчилсан улс орнуудын намын бүтэц зохион байгуулалтын хөгжлийн ерөнхий чиг хандлага нь дараах хэдэн асуудлууд дээр төвлөрч, тэдгээрийг нийгмийн хөгжил, ардчиллын суурь зарчмуудад нийцүүлэн бэхжүүлж байгаа бөгөөд глобаль улс төрийн бодлогын шинэ эринд МАХН ч энэ шинэчлэлээс ангид байх учиргүй. Үүнд:

- Нам доторх эрх мэдлийн хуваарилалт түүний зохион байгуулалтын эрх зүйн үндсийн дэвшилтэт механизмыг хэвшүүлэх, энэ нь намын дотоод ардчиллыг төлөвшүүлэхэд үйлчилдэг байх.
- Намын бүх шатны байгууллагуудын хоорондын харилцаанд дээрээс чиглүүлж удирддаг арга барилаас ангижирч бүх асуудлыг тулган хүлээлгэх замаар (вертикаль) бус дороос, анхан шатны нэгжүүдийн үүрэг ролийг дээшлүүлэх (горзонталь), тэдний санал санаачлагыг намын бодлогод илүү тусгах ингэснээр сонгогчдод илүү ойр ажиллах боломж, нөхцлийг сайжруулах
- Боловсон хүчнийг шилж сонгох шударга механизмыг боловсронгуй болгон хэвшүүлж, нээлттэй, хараат бус байх орчин бүрдүүлэх.
- Намын гишүүдийн оролцоог шийдвэр гаргах үйл явцад нэмэгдүүлэх, намын байгууллагуудын илүү нээлттэй байдлыг бий болгох.

**Нэг: МАХН дахь эрх мэдлийн хуваарилалт, түүний зарчим.** МАХН-ын дүрмийн 8.2-т намын зохион байгуулалтын бүтцийг:

МАХН-ын удирдах байгууллага

Аймаг, нийслэлийн намын байгууллага

Намын анхан шатны байгууллага гэсэн гурван шатлалд хуваан үзэж тэдгээрийн хоорондын харилцаа, эрх мэдлийн хуваарилалт, шийдвэр гаргах үйл явцын чиглэлийг тодорхойлсон байна. Намын хөгжлийн практикаас үзэхүл намын зохион байгуулалтын бүтцийн шатлал, эрх мэдэл хуваарилалтын зарчмыг орон нутгийн засаг захиргааны нэгжид үндэслэн дээрх шатлалаар бий болгох ерөнхий чиг хандлага байх боловч эрх мэдэл, шийдвэр гаргах эрхийн уг



<sup>3</sup> ÌÀŌÍ-úí áááà óóóéúí ÌÌ óóóáéääáí. Èèòáýé,áàðèèò áè-ā¿¿ä.ŌÁ.,2005 ïí.óóóääñ.11

сурвалж хаанаас гарч байгаагаараа хоорондоо ялгагддаг аж. Энэ нь намын дотоод ардчиллын нэг том шалгуур юм. МАХН-ын дүрмийн 9.1-д “МАХН-ын удирдах дээд байгууллага нь намын Их хурал, төлөөллийн төв байгууллага нь МАХН-ын Бага хурал байна”, мөн дүрмийн 10.1-д “МАХН-ын гүйцэтгэх удирдлагыг Удирдах Зөвлөл, аймаг, нийслэлийн намын хорооны болон анхан шатны байгууллагын тэргүүлэгчид өөрийн харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд тус тус хэрэгжүүлнэ” гэж заажээ. Гэвч намын удирдлагын дээрх байгууллагуудыг хаанаас байгуулан ажиллуулах зарчим нам доторх эрх мэдэл хуваарилалт, дотоод ардчиллын үндсийг гаргах гол сэжим болох учиртай бөгөөд шийдвэр гаргах эрх мэдлийн эх сурвалж хаанаас урган гарч дүрэмд тусгагдсан нь ихээхэн анхаарал татсан сонирхолтой асуудал юм. Дүрмийн 15.1-д “Намын Бага хурал нь намын Их хурлаас 4 жилийн хугацаагаар сонгосон 250 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байна”, мөн дүрмийн 21.2-т “Удирдах зөвлөлийг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Нарийн бичгийн даргыг оролцуулан 19-21 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Бага хурлаас 4 жилийн хугацаагаар сонгоно” гэж тус тус зааж өгсөн нь нам дотор удирдлагын босоо тогтолцоог хэлбэршүүлж, эрх мэдлийн төвлөрлийг бий болгоход үйлчилэхээр болжээ. Мөн дүрмийн 21.1-д “МАХН-ын Удирдах Зөвлөл нь намын гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэж заасан нь гүйцэтгэх байгууллагад эрх мэдэл, удирдлагын хэт төвлөрөл бий болгоход чиглэгдсэн байгаа бөгөөд агуулгын хувьд логикийн зөрчилтэй заалт болжээ гэж үзэх үндэслэл байна. Учир нь улс төрийн шинжлэх ухаанд “Удирдах” хэмээх нэр томъёо “гүйцэтгэх” гэсэн ойлголттой агуулгын хувьд, улс төрийн практикт тогтсон байдлын хүрээнд эрх мэдлийг хуваарилах салаа утгатайгаар хэрэглэгддэг бөгөөд энэ үүднээсээ дээрх заалт нь өөрөө өөртөө (удирдах зөвлөл удирдах зөвлөлдөө) зориулсан шийдвэр гаргаж түүнийгээ өөрсдөө гүйцэтгэх утгыг агуулжээ.

Намын орон нутгийн байгууллагуудад эрх мэдэл яаж хуваарилагдах нь нам доторх ардчиллыг хэмжих нэг үзүүлэлт байдаг. Энэ нь нам доторх эрх мэдлийн тархалтын хэмжээ, түүний зүй зохист харьцаагаар илэрхийлэгдэнэ. Орчин үед намын орон нутгийн нэгжүүдэд өргөн эрх мэдлийг өгч байгаа нь намын дунд болон анхан шатны нэгжүүдэд эрх мэдлийн давуу эрхийг олгосноор, нам бодлого боловсруулж түүнийгээ хэрэгжүүлж үр дүн гаргаад сонгогчдоор дүгнүүлдэг биш, харин тэрхүү бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон түмнийг идэвхтэй оролцуулан үр дүнгийг нь хариуцдаг байгууллага болон хувирах төлөв дэлхий дахинд ажиглагдаж байгаагаар илэрч байна. Алив намын анхан, дунд шатны байгууллагууд нь сонгогчдод хамгийн ойр байж тэдний хүсэлт, шаардлагыг хүлээн авч намын бодлого, үйл ажиллагаанд тусгуулах чухал үүрэг бүхий нэгжүүд байдагт хэргийн гол учир оршино. МАХН-ын дүрэмд аймаг, нийслэлийн хурлуудын эрх, хэмжээг тухайн шатны хурлуудаас сонгогдсон байгууллагуудын (аймаг, нийслэлийн намын хороо, хяналтын хороо гэх мэт ) үйл ажиллагааны талаарх тайланг сонсох, үнэлэлт дүгнэлт өгөх төдийхнөөр хязгаарлагдмал хүрээнд зааж өгсөн, сум, дүүргийн хороо, баг, хорооны үүрийг байгуулах зарчим нь сонгуулийн бус зарчмаар өөрөөр хэлбэл дээрээс аймаг, нийслэлийн хорооны тогтоолоор байгуулж буй явдал нь анхан шатны нэгжид удирдлагын төвлөрөл бий болгох таатай нөхцөл болсон байна. Мөн дүрэмд намын дунд болон анхан шатанд намын удирдах дээд байгууллагуудад хүмүүсийг сонгох ямар ч эрх мэдлийг өгөөгүй байгаа нь нам дотоод ардчилалгүй болоход үйлчлэх боломжтой. Харин Ардчилсан намын үндсэн дүрэмд намын дунд болон анхан шатны нэгжид удирдах дээд байгууллагуудад (Гүйцэтгэх зөвлөл, Үндэсний зөвлөлдөх хорооны

гишүүн, Нийслэлийн намын зөвлөлдөх хорооны гишүүд, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах гэх мэт) хүмүүсийг сонгох эрх олгогдсон байгаа нь нам доторх ардчиллыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ. Тухайлбал: АН-ын Үндсэн дүрмийн 5.3.5-д “Аймаг, дүүргийн намын хорооны хурлаас УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг тодруулан ҮЗХ-ны хуралд оруулна”, мөн дүрмийн 5.3.6-д “Дотоод сонгуулийн хорооноос тогтоосон мандатын дагуу ГЗ, ҮЗХ-ны гишүүн, Нийслэлийн намын Зөвлөлдөх хорооны гишүүдийг нууц санал хураалтаар тодруулна” гэж заасан бол МАХН-ЫН дүрмийн 27.1.2-т аймаг нийслэлийн бага хурлын эрхийг заахдаа “Аймаг, нийслэлийн намын хорооны тайланг хэлэлцэх”, 27.1.3-т “Аймаг, нийслэлийн намын Хяналтын хорооны тайланг хэлэлцэх”, 27.1.4-т “Аймаг, нийслэлийн намын хороо болон Хяналтын хорооны бүрэлдэхүүний тоог тогтоож дөрвөн жилийн хугацаагаар сонгох” зэрэг эрхүүдийг тусгажээ. Үүнээс үзэхүл МАХН-ын аймаг, нийслэлийн болон анхан шатны нэгжүүдэд орон нутгийн хийгээд тухайн шатны хүрээнд үйл ажиллагаа явуулах эрхийг нарийн зааж өгснөөс бус удирдах дээд байгууллагуудын гишүүдийг сонгох, намын удирдлагын шийдвэр гарахад нөлөөлөх нөлөөллийн механизмыг тодорхойлсон заалт огт байхгүй байгаа нь тус намд удирдлагын “олигархи” бүтцийг бэхжүүлэх боломжийг дүрмээр бий болгожээ гэж дүгнэж болохоор байна.

Энд МАХН, АН-ын удирдах байгууллагуудын байгуулагдах зарчмыг харьцуулбал:



**Хоёр: Хүний нөөц ба намын гишүүдийн оролцооны асуудал.** Боловсон хүчнийг шилж сонгодог шударга механизмыг бий болгох, нээлттэй орчинг бүрдүүлэх, намын гишүүдийн оролцоог шийдвэр гаргах үйл явцад нэмэгдүүлэх, намын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж сонгогчдод хүрч ажиллах бүтцүүдийг бүрдүүлэх нь эрх баригч намын хувьд МАХН-д чухал ач холбогдолтой. Энэ чиглэлд МАХН-ын 2005 оны 12-р сарын 12-ны өдөр хуралдсан Бага хурлын III хуралдаанаас гаргасан “Хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгох, дэвшүүлэх, хариуцлага тооцох журам”, “МАХН-ын сургалт, судалгааны ажлын талаар баримтлах бодлогын чиглэл”, “МАХН-ыг мэдээлжсэн улс төрийн байгууллага болгох Цахим-МАХН хөтөлбөр” зэрэг боловсон хүчнийг шилж сонгох шалгууруудыг тодотгосон, намын идэвхтнүүд тэдгээрийг сурган чадваржуулах болон намыг орчин үеийн мэдээлжсэн нам болгоход чиглэсэн журмууд гарчээ.

МАХН-ын хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгох, дэвшүүлэх, хариуцлага тооцох журмын 5.1-д улс төрийн албан тушаалд томилогдох хүмүүст дараах шалгууруудыг тавихаар заасан байна. Үүнд:

- Улс төрийн шалгуур
- Ажил мэргэжлийн шалгуур
- Ёс суртахууны шалгуурууд оржээ

Гэвч дээрх шалгуурууд нь дүрмийн хүрээнд, түүний заалтуудад нийцүүлж боловсрогдсон тул боловсон хүчнийг сонгон шалгаруулах, тэдгээрийг улс төрийн болон төрийн хариуцлагтай албан тушаалд дэвшүүлэхэд намын анхан, дунд шатны байгууллагуудын эрх мэдэл санал оруулах төдийхнөөр хязгаарлагдаж байгаа нь ойлгомжтой байна. Учир нь намын дүрэм дэхь боловсон хүчнийг дэвшүүлэх энэ талын заалтууд нь намын удирдах дээд байгууллагуудын (Бага хурал, Удирдах зөвлөл) эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн байдагтай холбоотой. Тухайлбал уг журмын 6.1, 6.2, 6.3, 6.4 дэхь заалтууд үүнд хамаарч байна.

Намын шийдвэр гаргах үйл явцад жирийн гишүүдийн санаа бодол, оролцоог нэмэгдүүлэх асуудал нь нам доторх ардчиллыг төлөвшүүлж, намын удирдлага нийт гишүүдийнхээ өмнө ажлаа тайлагнадаг, хариуцлага хүлээдэг байх ардчилсан зарчмыг хангахад чухал ач холбогдолтой байдаг. Иймд намын шийдвэр гаргах үйл явцад жирийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга механизм нь юуны өмнө анхан шатны нэгжүүдийн статус, эрх мэдлийг нэмэгдүүлснээр биелэлээ олдог аж. Учир нь намын анхан шатны нэгж бол намын бодлого шийдвэрийг сонгогчдод хүргэх хамгийн дөт механизм бөгөөд энэ нэгжүүд хэр сайн ажилласанаас нам сонгуульд ялах ялагдахын хувь заяа шийдэгддэг. МАХН-ын өнөөгийн дүрмээс харахад намын удирдлага ажлаа тайлагнах, гишүүдийн зүгээс түүнд хариуцлага тооцох механизм тусгагдаж өгөөгүй байгаа нь намын удирдлага хариуцлагаас мултрах, алдаатай алхмуудынхаа төлөө хариуцлага хүлээх асуудал бүрхэг хэвээр байхад үйлчлэхээр байна. МАХН-ын “Хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгох, дэвшүүлэх, хариуцлага тооцох журам”-ын 7.7-д “УИХ-ын болон орон нутгийн сонгуульд амжилтгүй оролцсон намын байгууллагууд шат шатандаа (МАХН-ын дарга, намын удирдах зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн МАХН-ын хороо, үүрийн дарга, тэргүүлэгчид) огцрох өргөдлөө гаргана. Дээд шатны байгууллага өргөдлийг даруй авч хэлэлцэн зохих шийдвэрийг гаргана” гэсэн заалт нь намын байгууллагууд болон хариуцлагтай албан тушаалтнуудад намын өмнө үйл

ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээхийг тодорхойлж өгсөн заалт мөн боловч энэ нь зөвхөн сонгуулиар хязгаарлагдаж бусад үед алдаа, эндэгдэлтэй үйлдлийнхээ төлөө хариуцлага механизм бүрхэг байгаа юм.

Намын бүтэц, зохион байгуулалтын асуудал дотор намын парламент дахь бүлэг, нам хоёрын хоорондын харилцааны асуудал чухал байр суурь эзэлдэг. Парламент ёс хөгжиж, намын төлөвшил жигдэрсэн орнуудад дээрх хоёрын харилцаанд үндсэн хоёр хэв маяг оршиж байна.

1. Парламент дахь намын бүлэг нь намын хөтөлбөр, программ, шийдвэрүүдийг удирдлага болгон парламент дахь үйл ажиллагаагаа явуулдаг хэлбэр. Иймэрхүү харилцаа зүүний чиглэлийн намууд, тэдгээрийн парламентын бүлгийн хооронд тогтсон байдаг. МАХН, түүний парламентын бүлгийн үйл ажиллагаа энэ хэлбэрт багтана. Тиймээс намаас гаргасан улс төрийн шийдвэр парламентын гишүүдийн хувьд үүрэг болон хэрэгжих замаар явагдаж байна. МАХН-ын дүрмийн 34.5 дахь “МАХН-ын удирдах байгууллага намын бодлогын асуудлаар бүлэгт чиглэл өгч болно” гэсэн заалт нь намын сахилга батыг парламентын хүрээнд бэхжүүлж ажиллахад чиглэсэн нь харагдаж байна. Нөгөө талаар энэ нь парламентын бүлгийн удирдагчдыг намын удирдах албан тушаалд байлгах шаардлагыг заавал бий болгодог сайн талтай. Энэ практик манай улс төрийн намуудад тэр дундаа МАХН-д биелэлээ олсон байна. Намуудын үйл ажиллагаа, сонгуулиас сонгуулийн хооронд, сонгуулийн дараа парламентад бодлого, үйл ажилаагаа, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө картель намуудын хэлбэрээр ажиллах болсон намын хэв маяг давамгайлж буй өнөө үед энэ хэлбэрээр явах нь илүү үр дүнд хүрч намуудыг нийгэмд үйлчилдэг институт болгоход ихээхэн түлхэц өгч байна.

2. Намын парламентын бүлэг нь нэлээд бие даасан байж парламентад өрнөж буй улс төрийн нөхцөл байдалд намын үйл ажиллагаагаа зохицуулж нийцүүлдэг хэлбэр. Энэ хэлбэр ихэнхдээ парламентад байнгын гишүүнгүй жижиг намуудад илэрдэг.

Дээр дурьдсан бүгдээс дүгнэж үзэхэд МАХН-ын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо нь удирдлагын төвлөрлийг бий болгосон шинжийг давамгайл агуулсан байна. Иймэрхүү бүтэц нь орчин үед намуудын үйл ажиллагааг жирийн сонгогчдод хүргэх, тэдний дуу хоолойг сонсох, гишүүддээ үйлчлэхэд төвөг бэрхшээлт байдлуудыг үүсгэхэд хүргэж байгаа бөгөөд зүүний чиглэлийн ихэнх намууд ийм бүтцээсээ аль болох татгалзах бодлогыг барьж байна. МАХН ч энэ шинэчлэлээс ангид байлгүйгээр шинэчлэгдэх нь цаг үеийн шаардлагад нийцсэн чухал алхам болох юм.

#### **Ашигласан материал**

1. Б.Болд-Эрдэнэ. Монгол дахь нам, намын систем. УБ., 2001 он
2. Richard S. Katz and Peter Mair. Cadre, Catch-All or Cartel. Report. The Harvard International Journal of Politics. Vol 2. p.525-534., 1996
3. С.Мөнхбат. Улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Политологи сэтгүүл. 1 2. УБ., 2005 он
4. Үндсэн хууль. УБ., 1992 он
5. Намын тухай хууль. УБ., 2005 он
6. МАХН-ын дүрэм. МАХН-ын XXIҮ их хурал. Илтгэл, баримт бичгүүд. УБ., 2005 он
7. МАХН-ын Бага хурлын III хуралдаан. Илтгэл, баримт бичгүүд. УБ., 2005 он
8. Ардчилсан намын Үндсэн дүрэм. УБ., 2006 он